



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2021 – 07 САР | ДУГААР 32

## ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5 Зохицуулалтын мэдээ
- 5–7 Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- 8–9 ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ
- 10 РЕГТЕК ТЕХНОЛОГИ БОЛОН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ
- 11–12 УУР АМЬСГАЛЫН САН
- 14–17 Судлаачын ИНДЕР
- 18–19 Хэрэглэгч
- 20 ТУЗ-ийн шинэчлэлт

## САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО

**ЭРХ ЗҮЙН ОРЧИН:** Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын 40 зөвлөмжид үл хөдлөх хөрөнгийн зуучлал гэж эрх бүхий байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрөл эсхүл бүртгэлтэй мэргэжлийн баг, мэргэжилтнээр дамжуулан үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, худалдан авах болон түрээслэх, түрээслүүлэх гэх мэт гэрээ хэлэлцээрийг зохион байгуулахыг ойлгоно. Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгөд холбогдох гэрээний дүнгээс тодорхой хувийг зуучлалын хөлс хэлбэрээр авч цалинжих боловч харилцагч, үйлчлүүлэгчийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төлбөрийг зуучлагчийн дансаар дамжуулах тохиолдол цөөнгүй байдаг. Иймд “Зуучлалын гэрээ хэлэлцээрийн хүрээнд хийгдэх төлбөр нь бэлэн, бэлэн бусын аль нь болох, мөн мөнгөний эх үүсвэрийн талаар эрх бүхий байгууллагад тайлагнаж, холбогдох мэдээ, мэдээллээр хангадаг байх” нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ гэж ФАТФ үздэг.

Манай улсын хувьд иргэд, аж ахуйн нэгжүүд үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллагыг төдийлөн сонгож үйлчлүүлдэггүй, нөгөө талаас тус салбарт өрнөж буй үйл ажиллагааны бүртгэл, хяналт зохицуулалтгүйгээс салбарын статистик тоон мэдээлэл хангалтгүй байсан. Үнэт металл, үнэт чулуу болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны хувьд мөн адил төрийн зохицуулалтгүй байсан тул мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх өндөр эрсдэлтэй гэж үзэн ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын хуралдаанаар Монгол Улсыг “Саарал жагсаалт”-д оруулахад нөлөөлсөн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, хяналтыг сайжруулах цогц арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлт нь мэдээлэх үүрэгтэй этгээд болох санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч /СББМҮҮ/-ийн үйл ажиллагааны чиглэл буюу “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч”-ийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр хуульчилсан.

Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 78 дугаар тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны зохицуулалтын стратеги бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, оролцогчдын үйл ажиллагааны дүрэм, журам, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандартыг тогтоох, салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгох, учирч болзошгүй эрсдэлээс зах зээлд оролцогчдыг хамгаалах, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий “Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар” байгуулагдсан бөгөөд шинээр зохицуулалтад орсон 2 салбарын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан бие даасан хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага зүй ёсоор тулгарсан. Иймээс Дэлхийн банкны төслийн хүрээнд үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооллыг судалсны үндсэн дээр салбарын үйл ажиллагааг зохицуулах анхдагч хуулийн төслийг боловсруулахад зөвлөх авах ажлыг зохион байгуулан шийдвэрлүүлээ.

**ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙГ БҮРТГЭЛЖҮҮЛЛЭЭ:** Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран ажиллаж, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамрагдаж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 230 хуулийн этгээдийн, үл хөдлөх хөрөнгийн зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 6,728 хуулийн этгээд буюу нийт 6,958 хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлээс Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн 2020 оны 4737 тоот дүгнэлтээр дээрх үйл ажиллагааны төрлүүдийг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлээ.

2021 оны 6 дугаар сарын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 205 хуулийн этгээд, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 415 иргэн, 38 хуулийн этгээдэд олгож, 226 брокер, 1,252 агентыг Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэлээ. Бүртгэлжүүлэх ажлыг боловсронгуй болгох, цахимжуулах ажлын хүрээнд төрийн байгууллагуудаас “ХҮР” системээр дамжуулан авах лавлагаа, тодорхойлолт мэдээллийг авч байхаар зохион байгуулж, “Зөвшөөрлийн цахим систем”-ийг ашиглан тусгай зөвшөөрлийн холбогдох баримт, бичгийг хүлээн авч, хянаж, баталгаажуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн онцлогтой.

## ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- Засгийн IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC\_of\_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

Үргэлжлэл 2-р нүүрт >>



**ТАНЫ  
САНХҮҮГИЙН  
МЭДЛЭГТ**

**ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ**

Хөрөнгийг байгууллагын тайлан тэнцэлд бүртгэснээс хойш үнэ цэнэ буюу өртгөөс нь хорогдуулан тооцсон элэгдлийн зардлын нийт дүн.



**ACCUMULATED DEPRECIATION**

The total amount of the depreciation written off the cost or valuation of a fixed asset since it was brought into the balance sheet of an organization .

*Эх сурвалж:*

*Банк санхүүгийн тайлбар толь бичиг*



**БОДЛОГЫН НИЙТЛЭЛ**

**САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭГЧДИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ  
ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО**

*Эхлэл 1-р нүүрт >>*

**ХОЛБООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА:**

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой учирч болзошгүй эрсдэл, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэх, мэргэжлийн үйл

чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоо” ГҮТББ, “Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ байгуулагдаж, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах хүсэлт ирүүлснээр олон ажлуудыг хамтран хийх үндэс тавигдсаны нэг “Сургалт зохион



ажиллагааг хэрхэн явуулах талаар тогтмол сургалт өгч, сүүлийн үеийн мэдээллээр хангах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 1048 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”, 2021 оны 152 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”-ыг тус тус баталсан.

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид өөрийн гишүүдэд үйлчилж, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой “Үнэт металл, үнэт

байгуулах гэрээ”-г үзэглэсэн явдал юм. Мэргэжлийн байгууллагуудын чадварыг дээшлүүлэх, анхны эрх олгох сургалтыг эрх зүйн зохицуулалт, олон улсын жишиг, хандлага, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай, тайлан мэдээ гаргах зааварчилгаа, Фин-А систем ашиглах аргачлалын талаар болон холбогдох бусад сэдвээр хийгдсэн нь мэдлэг олгосон, шинэ мэдээлэл хүргэсэн ажил болсон.

Мөн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч болон үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллагад зориулсан гарын авлагыг хэвлүүлэн гаргаж, Холбооны гишүүдэд болон иргэд, олон нийтэд хүргүүлэн ажилласан нь мөнгө угаах болон терроризмыг

санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлсэн алхам боллоо.

**ЦААШДЫН ТӨЛӨВ:** Сүүлийн жилүүдэд мэдээлэл технологи болон түүнд суурилсан үйлчилгээнүүд хурдацтай хөгжихийн хэрээр иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөн илүү ухаалаг, үр ашигтай үйлчилгээг сонгон үйлчлүүлэх болсон. Үүнийг дагаад төрийн үйлчилгээг олон нийтэд хүргэхдээ уламжлалт аргаар бус цахим хэлбэрт шилжүүлж, түргэн шуурхай хүргэх, хялбаршуулах зайлшгүй нөхцөл, шаардлагатай тулгарч байна. Нөгөө талаас төрийн үйлчилгээг цахимжуулснаар үр ашиггүй зардлыг хэмнэх, ажилтанд үүсэх механик ачааллыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, харилцагч иргэн, байгууллагууд орон зайнаас үл хамаарч, цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой. Иймээс төрийн зохицуулагч байгууллагууд нь нэгдмэл мэдээллийн нэгдсэн системтэй, уялдаа холбоотой ажиллах нөхцөл суурийг бүрдүүлж эхлээд байна. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газартай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд тусгай зөвшөөрөлтэй иргэдийн худалдан борлуулсан бүтээгдэхүүний төлбөрийн баримтыг татварын QR баримтаар олгох нөхцөлийг бүрдүүлэхээр “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ-тай хамтран үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн борлуулалтыг НӨАТ-ын системээс татан авах боломжийг бүрдүүлсэн нь борлуулалтын мэдээг тусгай зөвшөөрөлтэй иргэн хуулийн этгээдээс ирүүлэх бус татварын системээс тухай бүр татаж авах бололцоог бүрдүүлж, тайлагнал санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажих боломжийг бүрдүүллээ.

Манай улсын ард иргэд эрт үеэс үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийг ахуйн хэрэглээнд өргөн ашиглаж ирсэн бөгөөд Монгол хүний уламжлалт ур шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахдаа олон улсын стандарт, аргачлалыг дотоодын зах зээлд нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний

гарал үүсэл, нийлүүлэлтийн сувгийг технологийн тусламжтайгаар ил тод нээлттэй болгох зэрэг шаардлага үүсээд байна. Ингэснээр хаана олборлогдсон, эсвэл үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн, хэн гэдэг арилжаа эрхлэгч дээр борлуулагдаж буйг мэдэх, хянах боломж бүрдэж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь өөрийн борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд баталгаа гаргах, хэрэглэгчийн хувьд найдвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэт эдлэлийг худалдан авах боломж бүрдэх юм.

Мөн мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан бараа, таваарын цахим зах зээл /бирж/-ийг хөгжүүлэх боломж бүрдүүлснээр дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчдад өөрийн хүссэн бараа бүтээгдэхүүнийг арилжаалах, хөрөнгийн зах зээлийн идэвхийг нэмэгдүүлэх үндэс тавигдана гэж харж байна.

Цаашид Санхүүгийн зохицуулах хороо дотоодын зах зээлд төдийгүй олон улсын зах зээлд СББМҮҮ үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахад анхаарч байна. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, хөрөнгө оруулалтын орчинг бүрдүүлэх нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг болон татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх, далд эдийн засгийг ил болгох, тодорхойгүй мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байх, уг салбарт учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ авах нөхцөлийг буй болгоход олон улсын стандартыг тасралтгүй хангаж ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.



## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА ИРҮҮЛЭХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын зургаан салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүд хагас болон бүтэн жилээр “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг цахим хэлбэрээр бөглөн ирүүлдэг.

Хэрэв энэхүү эрсдэлийн үнэлгээний асуулгыг бөглөн ирүүлэхгүй байх, дутуу бөглөх эсвэл хугацаа хоцроох, мэдээлэл үнэн, зөв бус байх нь тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдийг эрсдэл өндөртэй гэж үзэж газар дээрх хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлэх, нэмэлт мэдээлэл шаардах үндэслэл болдог.

Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд нь 2021 оны эхний хагас жилийн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг доорх холбоосоор татан авч 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөж ирүүлэхийг мэдэгдэж байна.

1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд: sec\_amlcft@frc.mn
  2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид: ins\_amlcft@frc.mn
  3. Банк бус санхүүгийн байгууллагууд: nbfi\_amlcft@frc.mn
  4. Хадгаламж, зээлийн хоршоод: scc\_amlcft@frc.mn
  5. Үл хөдлөх, эд хөрөнгө зуучлалын байгууллагууд: rea\_amlcft@frc.mn
  6. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд: dpms\_amlcft@frc.mn
  7. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хувь хүн: dpms\_amlcft@frc.mn
- Шаардлагатай нэмэлт мэдээллийг дээрх и-мэйл хаягууд мөн amlcft@frc.mn болон +51-261113, +51-261112 утсаар тодруулна уу.

### БИНАНС БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗАРИМ УЛСАД ХОРИГЛОЖЭЭ

Английн Санхүүгийн зохицуулагч байгууллагаас дэлхийн хамгийн томд тооцогддог Бинанс криптовалютын биржийн үйл ажиллагаа явуулахыг тус улсад хориглосон тухай мэдэгдлийг өнгөрсөн 6 дугаар сарын 26-ны өдөр цахим хуудаснаа нийтэлсэн байна. Уг мэдэгдэлд өндөр өгөөж амласан криптовалютын хөрөнгө оруулалтыг сурталчилсан аливаа үйл ажиллагаанаас болгоомжлохыг анхааруулжээ. Бинанс нь Англид улсад үүсгэн байгуулагдаагүй ч тус улсын Санхүүгийн зохицуулагч байгууллагад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагад нийцээгүй учраас бүртгэгдээгүй байна.

Түүнчлэн дэлхийн бусад улс орны зохицуулагч байгууллагуудаас Бинансын талаар анхааруулга, мэдэгдлийг удаа дараа гаргасаар байна. Тухайлбал, Японы Санхүүгийн үйлчилгээний агентлагаас тус биржийг зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй талаар олон нийтэд анхааруулжээ. Мөн Германы Санхүүгийн зохицуулагч байгууллагаас Бинанстай холбоотой мэдэгдэлдээ хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга гаргалгүйгээр дижитал токен гаргаж эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгосон талаар мэдээлсэн бол Канад Улсын Онтариогийн Үнэт цаасны тухай хуульд нийцээгүйн улмаас тус биржийн Онтариод үйл ажиллагаа явуулахыг зогсоосон байна. Үүнээс гадна тус биржийн охин компани болон “Бинанс холдинг” ХХК-ийг энэ оны 5 дугаар сард АНУ-аас мөнгө угаасан байж болзошгүй, татвараас зайлсхийсэн зэрэг гэмт хэрэгт сэжиглэн шалгаж эхэлжээ. АНУ-ын “Chainalysis” буюу криптовалютын судалгаа шинжилгээ, мөрдөн шалгах үйлчилгээ үзүүлдэг

байгууллагаас гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгө бусад биржээс илүү Бинансаар дамжсан тухай мэдээлсэн байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос иргэд Та бүхнийг өндөр ашиг, үр өгөөж амласан криптовалют, виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаанаас болгоомжилж, өөрийгөө эрсдэлээс хамгаалахыг анхааруулж, эдгээр үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй, үнийн савалгаа ихтэй, баталгаагүй болохыг дахин сануулж байна.

### ГАРААНЫ КОМПАНИ ХУВЬЦААГАА БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ ЖУРМЫН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА

Инновацийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т “Гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 995 дугаар тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулан олон нийтээс санал авлаа.

### ИРГЭД, ДААТГУУЛАГЧДЫГ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРЭМЖЛҮҮЛЖ БАЙНА

Сүүлийн үед цахим орчинд “Нэмэх даатгал” гэх тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүнийг олон нийтэд санал болгон, иргэдээс мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлж, тодорхой хугацааны дараа 2 дахин үржүүлж өгнө гэх хууран мэхлэлт, залилангийн шинж чанартай үйл ажиллагааг тодорхой нэр бүхий этгээдийн зүгээс зохион байгуулж байж болзошгүй байна.

Даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “... Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно”, мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т “Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд “даатгал”, эсхүл “даатгал” гэсэн үгний төрөл үг хэрэглэх, даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл уг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц нэр томъёо ашиглах болон тэдгээртэй адилтгах бусад үйлдэл хийхийг хориглоно” гэж тус тус заасан байдаг.


Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй аливаа этгээдтэй даатгалын гэрээ байгуулж, хураамж, шимтгэл, төлбөр төлөх болон иргэдээс татсан мөнгөн хөрөнгийг 2 дахин үржүүлж өгөх зэргээр өндөр хүү, өгөөж, үр шим амласан амлалтад залилуулж, хууран мэхлэгдэх эрсдэлтэй тул иргэд, олон нийтийн зүгээс дээрх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг авахын өмнө тухайн байгууллагын оноосон нэр, эрхлэх үйл ажиллагаа нь холбогдох эрх бүхий байгууллагаас олгогдсон зөвшөөрөлтэй эсэхийг нягталж, өөрт учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ үү.

Иргэд, олон нийтийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдын мэдээллийг www.frc.mn цахим хуудсанд нэвтэрч танилцана уу.

Мөн дээр дурдсан асуудлаар өргөдөл гомдол, хүсэлт, мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсаар болон 51-266420, 51-261275 дугаарт хандан гаргах боломжтой болно.

## БАЙР СУУРЬ

### САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



Хүртээмжтэй санхүү сэтгүүлийн 2021 оны 7 дугаар сарын ээлжит дугаарт Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтуяатай ярилцлаа.

**Сайн байна уу? Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийг хэзээнээс төр зохицуулж эхэлсэн бэ гэдэг асуултаас ярилцлагаа эхлүүлье.**

Хүртээмжтэй санхүү сэтгүүлийн уншигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Юуны өмнө ФАТФ болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид гэж хэнийг хэлээд байгаа талаар мэдээлэл өгөх нь зүйтэй болов уу.

1989 онд “Их долоо”-гийн шийдвэрээр ФАТФ буюу Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага байгуулагдсан 35 өндөр хөгжилтэй улс, 2 бүс нутгийн холбооны гишүүдийг өөртөө элсүүлсэн олон улсын байгууллага юм. Бүс нутаг хариуцсан байгууллагуудаараа дамжуулан өөрийн хяналтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Харин Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/ гэж Ази, Номхон далайн бүсийн нийт 41 улс, олон улсын байгууллага болон ажиглагч байгууллагуудыг нэгтгэсэн олон улсын хамтын ажиллагааны байгууллага байдаг. Монгол Улс нь АНДМУТБ-т 2004 онд гишүүнээр элссэн.

Олон улсын санхүүгийн системийн цогц байдалд аюул занал учруулж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх, бусад холбоотой заналхийлэлтэй тэмцэх хяналт, зохицуулалтын эрх зүйн орчин, үр дүнтэй байдлыг ФАТФ-ын батлагдсан аргачлалын дагуу үнэлдэг. ФАТФ-аас гаргасан “Чиглэл бүрээр хэрэгжүүлэх 40 зүйл заалт бүхий багц зөвлөмж”-ийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийн эсрэг олон улсын стандарт гэж хүлээн

зөвшөөрдөг.

Энэхүү зөвлөмжид дурдсанаар санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэдэгт үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах, нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчийг хамруулдаг байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

**Тэгэхээр ФАТФ-аас санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хангалтгүй гэж үзээд Монгол улсыг “Саарал жагсаалт”-д оруулсан уу?**

ФАТФ нь 2013 онд манай улсыг Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиндаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг хуульчлаагүй гэсэн шалтгаанаар “өндөр эрсдэлтэй болон хамтран ажилладаггүй улс” буюу “саарал жагсаалт”-д анх оруулж байсан. Тухайн үед

Улсын Их Хурлаас холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулснаар 2014 онд тус жагсаалтаас Монгол Улс гарч байсан. Дараа нь АНДМУТБ-ээс 2017 онд Монгол Улс нь ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх тайланг хэлэлцээд “Хангалтгүй” гэж дүгнэн “Саарал жагсаалт”-д дахин оруулсан тул Монгол Улс ФАТФ-аас өгөгдсөн үүрэг даалгаврыг 40 зөвлөмжид нийцүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Ингэснээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулахдаа уг 40 зөвлөмжийн дагуу санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэдэгт үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах, нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулан, эдгээр үйл ажиллагаа эрхлэгчдийг “Мэдээлэх үүрэгтэй этгээд”-д хамааруулан хуульчилсан.

ФАТФ-ын 40 зөвлөмжийг уншихад үл хөдлөх хөрөнгийн зуучлал гэж эрх бүхий байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрөл эсхүл бүртгэлтэй мэргэжлийн баг, мэргэжилтнээр дамжуулан үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, худалдан авах болон түрээслэх, түрээслүүлэх гэх мэт гэрээ хэлэлцээрийг зохион байгуулах, “Зуучлалын гэрээ хэлэлцээрийн хүрээнд хийгдэх төлбөр нь бэлэн, бэлэн бусын аль нь болох, мөн мөнгөний эх үүсвэрийн талаар эрх бүхий байгууллагад тайлагнаж, холбогдох мэдээ, мэдээллээр хангадаг байх” нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ гэж ФАТФ хүлээн зөвшөөрдөг байна.

АНДМУТБ нь ФАТФ-ын 40 зөвлөмжийн хэрэгжилтийн түвшинг үнэлэхдээ “Техникийн хэрэгжилт”-тэй холбоотой ФАТФ-ын 40 зөвлөмжийг тухайн улсын хууль, журамд тусгагдсан эсэхийг харж үнэлдэг бол харилцан үнэлгээний чухал хэсэг болох үр дүнтэй байдлын 11 үзүүлэлтээр ФАТФ-ын зөвлөмжүүд нь бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, “Харилцан

үнэлгээ”-ний тайланг ФАТФ-ын газар дээрх шалгалтаар баталгаажуулдаг юм.

ФАТФ-ын 40 зөвлөмжийн дагуу дэлхийн улс орнуудад үнэлгээг хийж, харилцан үнэлгээний тайлангийн дүгнэлтээр уг 40 зөвлөмжийг биелүүлэх хүсэл сонирхолгүй, эсхүл биелүүлэхээс татгалзсан улс орныг “өндөр эрсдэлтэй улс” гэж дүгнэн “саарал” болон “хар жагсаалт”-д оруулж анхааруулах арга хэмжээг авдаг.

Манай улсын хувьд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд үл хөдлөх хөрөнгийн зуучлалын байгууллагыг төдийлөн сонгож үйлчлүүлдэггүй, нөгөө талаас тус салбарт өрнөж буй үйл ажиллагааны бүртгэл, хяналт зохицуулалтгүйгээс салбарын статистик тоон мэдээлэл хангалтгүй байсан. Үнэт металл, үнэт чулуу болон тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны хувьд ч мөн адил төрийн зохицуулалтгүй байсан бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх өндөр эрсдэлтэй гэж тооцсон нь ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын хурлаар Монгол Улсыг “Саарал жагсаалт”-д оруулахад нөлөөлсөн нэг даалгавар болсон.

Дээр хэлсэнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчилсан нь тухайн салбаруудын үйл үйл ажиллагаа тусгай зөвшөөрөлтэй болж, салбарын статистик тоон мэдээллийн сан үүсэж, хяналт зохицуулалт бүрдсэн.

### Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар ямар чиг үүрэгтэй вэ?

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны зохицуулалтын стратеги



бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ хийх, оролцогчдын үйл ажиллагааны дүрэм, журам, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандартыг тогтоох, салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгох, учирч болзошгүй эрсдэлээс зах зээлд оролцогчдыг хамгаалах, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй.

Санхүүгийн зохицуулах хороо нь дээр дурдсан хуулийн хүрээнд шинээр зохицуулалт орсон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, сэргээх, хяналт шалгалт хийх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 9 журмыг Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар батлуулан, хэрэгжүүлж байна. Мөн шинээр зохицуулалт орсон 2 салбарын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан бие даасан хуулийн төслийг боловсруулах шаардлага үүсээд байгаа. Иймээс Дэлхийн банкны төслийн хүрээнд үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооллыг судалсны үндсэн дээр салбарын үйл ажиллагааг зохицуулах анхдагч хуулийн төслийг боловсруулахад зөвлөх үйлчилгээг авах ажлыг зохион байгуулан шийдвэрлүүлсэн. 2021 оны 8 дугаар сарын 01 –нээс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг чиглүүлэх гадаад зөвлөх, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийг боловсруулах Дэлхийн банкнаас шалгаруулсан дотоодын зөвлөхтэй Санхүүгийн зохицуулах хороо гэрээг байгуулснаар ажиллаж эхэлнэ.

### **Холбогдох журмууд батлагдсанаар ямар давуу тал гарч байна вэ?**

Өмнө нь хэлсэнчлэн ФАТФ–аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, Монгол Улс “Саарал жагсаалт”–аас гарахад энэхүү салбарын зохицуулалт чухал нөлөөг үзүүлсэн. Нөгөө талаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг болон татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх, далд эдийн засгийг ил болгох, тодорхойгүй мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байх, уг салбарт учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ авах

нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна. Түүнчлэн Сангийн сайдын 2020 оны 20 дугаар тушаалаар Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан “Үндэсний эрсдэлийн үнэлгээ”–г хийсэн. Энэхүү эрсдэлийн үнэлгээнд анх удаа СББМҮҮ нар буюу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг боловсруулан тайланг эцэслэн хүргүүлсэн.

2021 оны 6 дугаар сарын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 205 хуулийн этгээд, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 415 иргэн, 38 хуулийн этгээдэд олгож, 226 брокер, 1,252 агентыг Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэлээ. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлээгүй, улсын бүртгэлд бүртгэлтэй хуулийн этгээдүүдийг 2020 оны 9 дүгээр сарын 21–ний өдрийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө харьяалах улсын бүртгэлийн байгууллагад ирүүлэх, дээрх хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад хандаж холбогдох өөрчлөлтөө бүртгүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааны чиглэлийг улсын бүртгэлээс хасах, хүчингүйд тооцох талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын [www.burget.gov.mn](http://www.burget.gov.mn) цахим хуудаст байршуулан, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагааг зохион байгуулсан. Энэ хугацаанд Улсын бүртгэлийн байгууллагад хандаж холбогдох өөрчлөлтөө бүртгүүлээгүй нийт 6,958 хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдааны болон үл хөдлөх хөрөнгийн зуучлалын үйл ажиллагааны төрлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгосон. Иймээс цаашид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагын арга хэмжээг авч ажиллан, хариуцлагын хэлбэрт тохирсон арга хэмжээг авч ажиллаж байна. Цаашид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагын хэлбэрт тохирсон арга хэмжээг авч ажиллана.

*Ярилцсанд баярлалаа. Танд ажлын амжилт хүсье.*

## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### ҮНЭТ ЦААС БОЛОН КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Сүүлийн жилүүдэд IPO хийсэн компаниудын тоо эрчимтэй өсөн, хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах сонирхол нэмэгдэж байгаатай холбогдуулан нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаатай холбоотой зохицуулалтыг хөнгөвчлөх, хялбар шуурхай болгох, уг ажиллагааг андеррайтерийн компани зохион байгуулах нөхцөл, бололцоог сайжруулах, андеррайтерийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, үнэт цаас гаргагчаас ирүүлэх мэдээллийн төрлийг шинэчлэн маягтжуулах, нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг аудит, хууль, хөрөнгийн үнэлгээний компаниудад тавигддаг шалгуурыг өсгөх, олон улсын жишигт нийцүүлэх зэрэг хэрэгцээ, шаардлага үүссэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-аар ‘хувьцаа’ болон ‘өрийн хэрэгсэл’ гэх санхүүгийн хэрэгслүүдийг бүртгэхтэй холбоотой харилцааг хамтад нь буюу хувьцаа гаргахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан боловч өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой харилцааг ерөнхий байдлаар зохицуулж ирсэн.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-т Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож, санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр “Компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй холбоотой дүрэм, журам гаргаж, биржийн болон биржийн бус зах зээлээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх нөхцөл, шаардлагын хүрээнд “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулга болон “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг боловсруулж Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 11 дүгээр ээлжит хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Тус журмууд нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5333, 5334 дугаарт тус тус бүртгэгдсэн бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх юм.

#### I. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

##### ЖУРМЫН БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА

Тус журам нь 12 бүлэгтэй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцаа, хувьцаанд хөрвөх опцион болон өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, хасах, анхдагч зах зээлд байршуулах, захиалгыг бүрдүүлэх, худалдах, тайлагнах, үнэт цаас гаргагч, андеррайтер, арилжаа эрхлэх байгууллага, Санхүүгийн

зохицуулах хорооны эрх үүргийг тодорхойлох, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө, аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулна.

##### ЖУРАМД ШИНЭЭР ТУСГАСАН БОЛОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТУУД

Андеррайтер нь үнэт цаасны танилцуулга, бусад шаардлагатай баримт бичгийг бэлтгэх, хувьцааг анхдагч зах зээлд байршуулж, захиалгыг бүрдүүлэх, худалдахад ашиглах аргачлалын талаар үнэт цаас гаргагчтай тохиролцсон байх зохицуулалт тусгагдсан.

Андеррайтер нь хууль зүйн зөвлөгөө, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн дүгнэлт, бусад шаардагдах бичиг баримтын бүрдэлд хяналт тавихаас гадна туслах андеррайтертай хамтран хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан.

Үнэт цаас гаргагчийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй үнэт цаасыг бүртгэх зохицуулалт:

Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь өөрийн компанийн нэмж гаргах энгийн хувьцаанд суурилсан опцион, хөрвөх нөхцөлтэй өрийн хэрэгсэл / convertible bond/-ийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгасан.

Хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны зохицуулалт Нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулах, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан арга хэлбэрээр андеррайтер нь хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, захиалгыг бүрдүүлэх, худалдах, санхүүжилтийг татан төвлөрүүлэх, хөрөнгө оруулагчдад хуваарилахтай холбоотой харилцааг шинээр зохицуулж өгсөн.

Хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх үед хувьцааны үнэ ханш огцом өөрчлөгдөхөөс хамгаалах зорилгоор үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тусгаарлах /lock up/, анхдагч зах зээлийн арилжаанд захиалгын эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд хувьцааны тодорхой хувийг нэмж гаргах / green shoe/ зохицуулалтыг тус тус тусгасан.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа, зах зээл үүсгэгчийн чиг үүрэг

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сараас доошгүй хугацаанд андеррайтер нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх, уг ажиллагаанд баримтлах зарчим,

андеррайтер, зах зээл үүсгэгчийн үүрэг, хариуцлага, арилжаа эрхлэх байгууллагын хяналт тавихтай холбоотой харилцааг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулсан.

Андеррайтер нь үнэ тогтворжуулах ажиллагааг туслах андеррайтер, эсхүл зах зээл үүсгэгчээр оролцох сонирхол бүхий бусад брокер, дилерийн компанитай хамтран хэрэгжүүлэх боломжтой байхаар тусгасан.

## ГАРАХ ҮР ДҮН

Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын банк буюу андеррайтерийн компани тухайн үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдах, хуваарилах замаар шаардлагатай урт хугацааны санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэг.

Үнэт цаасны бүртгэлийн журмын шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээр үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа хялбар болох, түүнд шаардагдах хугацаа багасах, уг ажиллагааг андеррайтерийн компани зохион байгуулснаар нийтэд санал болгохтой холбоотой зардал, өртөг буурах, арилжааны шимтгэлгүй болох, андеррайтерийн үүрэг, хариуцлага нэмэгдэн чадавхжих, компанийн нэр хүнд өсөх, хөрөнгийн зах зээлд чанартай бүтээгдэхүүний тоо өсөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо, сонирхол нэмэгдэх, хувьцааны арилжаа, хөрвөх чадвар өсөх зэрэг эерэг үр дүнг хөрөнгийн зах зээлд бий болгох чухал ач холбогдолтой юм.

## II. КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

### ЖУРМЫН БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА

Тус журам нь 9 бүлэгтэй бөгөөд журмын үйлчлэх хүрээ, хариуцлага, нийтэд санал болгон бонд гаргах этгээдэд тавигдах шаардлага, түүнд бий болж буй боломж, нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх, түүнийг гаргах, дараалал болон оролцогч талуудын эрх, үүрэг, бүртгэлээс хасагдах хүртэлх хугацаанд бонд гаргагчийн хэрэгжүүлэх үүрэг, бүртгэлээс хасах гэсэн бүтэцтэй бөгөөд хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулна.

### ЖУРАМД ТУСГАСАН ЗАРИМ ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТУУД

Бонд гаргагч андеррайтерийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэнд мэргэжлийн үйлчилгээ авах бөгөөд андеррайтер бондыг анхдагч зах зээлд худалдах, хуваарилалтыг хийх юм. Бонд гаргагчийн хүү, үндсэн

төлбөрийн эргэн төлөлт болон мэдээллийн ил тод байдалд андеррайтер хяналт тавих зохицуулалтыг тусгасан.

Тодорхой шалгуур шаардлагыг хангасан компаниуд, тухайлбал биржийн I ангилалд бүртгэлтэй этгээдийн гаргах бондыг Санхүүгийн зохицуулах хороо түргэвчилсэн журмаар буюу арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн тухай дүгнэлтийг үндэслэн ажлын 10 өдрийн дотор бүртгэнэ.

Бонд гаргагч нь Монгол Улсын “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу шинээр хэрэгжүүлэх эсхүл одоо хэрэгжүүлж байгаа төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор ‘ногоон бонд’ гаргаж болно.

Мөн эдгээр компани нь Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх буюу тодорхой үнийн дүн бүхий бондуудыг нэг удаа бүртгүүлж, хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгох боломжтой. Энэ нь тухайн компанийн бонд гаргахтай холбоотой цаг хугацаа болон зардлыг хэмнэх ач холбогдолтой.

## ГАРАХ ҮР ДҮН

Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам нь тухайн санхүүгийн хэрэгсэл гаргах харилцааг илүү тодорхой болгохоос гадна бонд гаргах хугацааг хэмнэх, бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг үйл ажиллагаа нь тогтворжсон этгээдэд олгосноор эрэлт нэмэгдэж, хөрөнгийн зах зээлд бонд гаргах аж ахуйн нэгж нэмэгдэнэ.

Нөгөөтээгүүр хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор андеррайтерийн компанийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлснээр бондыг худалдан авах хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэнэ.

Мөн андеррайтерийн компани нь бондыг нийтэд санал болгох, анхдагч зах зээлд худалдах, байршуулах үйл ажиллагааг зохион байгуулснаар 1/хөрөнгө оруулагчдаас гардаг байсан арилжааны шимтгэлийн зардал хэмнэгдэх, хэмнэсэн эх үүсвэрээр дахин хөрөнгө оруулах боломж бий болох, 2/богино хугацааны шинж чанартай, зохиомол эрэлт, нийлүүлэлт бий болгох замаар ханшийн савлагаа үүсгэх, зах зээлийг урвуулан ашиглах зэрэг зорилго бүхий хөрөнгө оруулагчид багасаж, тухайн бүтээгдэхүүний хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэхэд үнэ болон эрэлт, нийлүүлэлтийн тогтвортой байдал хангагдах ач холбогдолтой юм.



## ФИНТЕК БА РЕГТЕК

### РЕГТЕК ТЕХНОЛОГИ БОЛОН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ

Дэлхийн санхүүгийн зах зээл нүдэн дээр асар хурдацтай хөгжиж, тэр хэрээр санхүүгийн гэмт хэргийн хэлбэр, учруулах хор хохирол өсөн нэмэгдэж байна. Тэгвэл уг эрсдэлийг шийдэх гарцыг Регтек технологи хэмээн харж, улс орнууд үүн дээр төвлөрч ажиллах болжээ.

Сүүлийн үед финтек технологи хөгжин улс хоорондын мөнгөн гуйвуулга амар хялбар болсон нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн билээ. Мөн мобайл банкны хэрэглээний өсөлт, төлбөрийн системийн хөгжил, блокчейн технологийн хэрэглээ нь мөнгөн гуйвуулгын дүн өсөхөд нөлөөлж байна. Гэтэл нөгөө талдаа хэрэглэгчийн мэдээллийг нууцалсан бэлэн мөнгөний гүйлгээ нь санхүүгийн гэмт хэргийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болоод байна.

Тухайлбал, төлбөрийн карттай холбоотой гэмт хэрэг 2017 онд дэлхийн хэмжээнд 20 хувь өссөн буюу 28.84 тэрбум ам.долларт хүрсэн. Төлбөрийн залилан 2020 онд 2011 оны дүнтэй харьцуулахад гурав дахин нэмэгдсэн буюу 9.84 тэрбум ам.доллараас 32.39 тэрбум ам.доллар болж өссөн. Эдгээр эрсдэлүүд дэлхий дахинд санхүүгийн зах зээлд аюулын харанга дэлдсээр байгаа бол үүн дээр нэмэгдэж Ковид-19 цар тахалтай холбоотойгоор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой шинэ төрлийн залилангийн хэлбэрүүд бий болсоор байгаа юм.

Үүнд цар тахлаас үүдэлтэй хөл хорионы үеэр төлбөрийн картын мэдээллийг хулгайлан онлайн гүйлгээ хийх, онлайн гүйлгээ хийж байгаа хүний мэдээллийг хулгайлан бэлэн мөнгө авах, хуурамч компани байгуулж банкнаас зээл авах, олон нийтийн цахим сүлжээ ашиглан залилан хийх гэх мэт гэмт хэргийн шинжтэй үйлдлийг багтаан ойлгож болох юм. Нөгөө талаар мөнгө угаах гэмт хэрэгт хувийн санхүүгийн байгууллагууд өөрсдөө ч мэдэлгүй татагдан оролцож байгаа нь улс орны эдийн засагт их хэмжээний хохирол учруулж болзошгүй байна.

Олон улсын төрийн зохицуулалтын байгууллагууд энэ тал дээр хууль журмыг сайжруулах, хяналтын шинэ арга хэрэгсэл хэрэглэх зэрэг хүчин чармайлт гаргаж байгаа ч хангалттай үр дүнд хүрсэнгүй. Үүний гол шалтгаан нь технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний хөгжил нь төрийн зохицуулалтаас хурдан хөгжиж байгаатай шууд холбоотой юм. Иймд зохицуулагч байгууллагууд технологид суурилсан хяналтын аргачлал буюу "Регтек" хэрэглэх, хууль журмыг түүнд нийцүүлж хурдацтай шинэчлэх шаардлагатай тулгарч байна.

Регтек технологи нь бодит цагийн горимын зайны хяналтыг сайжруулж дээрх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломжтой бөгөөд хиймэл оюун ухаан, их өгөгдөл боловсруулах, машин сургалт болон блокчейн технологид суурилснаараа онцлог юм. Улс орны зохицуулагч байгууллагууд

регтек технологи хөгжүүлэгчдийн тусламжтайгаар өөр өөрсдийн хэрэгцээ шаардлагад тохирсон зайны хяналтын системтэй болж байна.

Жишээлбэл, Хонконгийн зохицуулагч байгууллага 2016 онд хязгаарлагдмал зохицуулалттай орчны сэндрбоксыг хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр банк болон финтек компаниудыг тодорхой хэмжээний оролцогчтойгоор хязгаарлагдмал зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж турших боломж олгосон. Мөн Дубайн зохицуулалтын байгууллага 2017 онд сэндрбоксд орсон финтек компаниудыг регтек технологиор хянаж эхэлжээ. Улс орнуудад уг технологийг амжилттай туршиж, хэрэгжүүлсэн сайн жишээ энэ мэт байгаа боловч олон улсын хэмжээнд регтекийн нэгдсэн бодлогогүй байгаа нь үндэстэн дамнасан санхүүгийн луйврыг хянах боломжийг хязгаарлаж байна. Тиймээс ФАТФ-аас энэ чиглэлийн дүрэм журам, заавар зөвлөгөө, стандарт гаргах болон регтекийн хөгжүүлэлтийг дэмжиж эхлээд байна.

Регтек буюу эрсдэлд суурилсан зайны хяналтын системийг бий болгохын тулд санхүүгийн байгууллагуудын технологийн ерөнхий бүтэц болон хяналтыг хэмжих индикаторуудыг тодорхойлох шаардлагатай байдаг. Нэгэнт санхүүгийн зах зээлд үйлдэгдэж буй гэмт хэргийг таслан зогсооход өндөр нөлөө үзүүлэхэд тустай технологи гэдэг утгаараа тус хяналтыг мөнгө угаах болон терроризмтой тэмцэх журмын хүрээнд боловсруулах хэрэгтэй. Эдгээр зүйлсийг тодорхойлсноор алсын зайн хяналтыг их өгөгдөл цуглуулах дэд бүтэц, түүнийг боловсруулах програм хангамжийн тусламжтайгаар хэрэгжүүлж болно.


Алсын зайн хяналтын индикаторуудыг хатуу зааж өгөх боломжгүй бөгөөд машин сургалт болон хиймэл оюун ухааны тусламжтайгаар түүний уян хатан байдлыг хангаж өгөх шаардлагатай. Мөн хиймэл оюун ухаан ашигласнаар тухайн байгууллагад үүсэж буй эрсдэлийг цаг тухай бүрд нь олж мэдэх боломжтой.

Регтек технологийн үр шимийг хүртэхийн тулд дан ганц нэвтрүүлээд орхих нь хангалтгүй бөгөөд талуудын өгөгдлүүд үнэн зөв байх нь хамгийн чухал. Тухайлбал, зохицуулагч байгууллага регтекийг хэрэглэж байгаа ч санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага мэдээллээ нуун дарагдуулах үед үр дүнгүй болно.



## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

### УУР АМЬСГАЛЫН САН



Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа

Сайн байна уу, уншигч танд “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн 32 дахь дугаараар уур амьсгалын сангийн талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ.

2015 онд НҮБ-аас Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг тодорхойлсны дараа тус оны 12 дугаар сард дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг улс орнууд нэгдэж Парисын хэлэлцээрийг баталж хэрэгжүүлсэн. Хэлэлцээрийн үндсэн зорилго нь дэлхийн дулаарлын түвшинг цельсийн 2 градусаас бага түвшинд хадгалах юм. Энэхүү зорилтод 2050 он гэхэд хүрэхийн тулд улс орнууд хүлэмжийн

хийн ялгарлыг боломжит түвшинд багасгахыг зорих болсон.

Хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах, түүнийг орлуулах төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт хамгийн чухал хүчин зүйл учраас өдгөө дэлхийн хамгийн том ногоон сан болоод байгаа Уур амьсгалын санг Парисын хэлэлцээрт хүрэхийн тулд байгуулсан. Уур амьсгалын сан (Climate green fund) нь 2015 онд үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 177 төсөл, хөтөлбөрт 33.3 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг хийгээд байна.



Уур амьсгалын сан нь хөгжиж буй орнуудыг дэмжих, тэдгээрийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах үндэсний хувь нэмрийг нэмэгдүүлж, дэлхийн дулаарлыг цельсийн 2 градусаас ихгүй хэмжээнд хадгалах зорилготой ба дараах

төслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр улс орнуудад санхүүжилтийг квотын дагуу олгодог. Үүнд:

- 1.Хөдөө аж ахуй;
- 2.Ой болон газар ашиглалт;
- 3.Барилга;
- 4.Хотжилт;
- 5.Үйлдвэрлэл;
- 6.Экосистем;
- 7.Энерги;
- 8.Эрүүл мэнд;
- 9.Хоол хүнс, усны аюулгүй байдал;
- 10.Дэд бүтэц;
- 11.Тээвэр зэрэг болно.

Уур амьсгалын сан нь улс орнуудад 3 түвшинд хөрөнгө оруулалт хийдэг ба үүнд зөвхөн төсөлд, зөвхөн бэлэн байдалд, эсвэл эдгээр хоёрыг нэгтгэсэн төсөл юм. Монгол Улсын хувьд төсөл болон бэлэн байдлын хоёр төрөл хоёулаа хэрэгждэг.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчин, уур амьсгалын сангаас гаргасан “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт” тайланд манай улсад нүүрлээд буй сорилтуудыг тодорхойлжээ. Тухайлбал “Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (НҮБ/УАӨСК)-ын Парисын Хэлэлцээрийг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр баталж, 2019 онд шинэчилж, хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилтоо ахиулан, тэргүүлэх зэргийн ач холбогдолтой арга хэмжээнүүдийг багтаасан “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” (ҮТХН/NDC) баримт бичгийг боловсруулсан.

Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их юм. Монгол Улс 2014 онд нийт 34,482.73 мян. т CO<sub>2</sub> –экв. (газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн салбарыг тооцоогүй) ялгаруулсны 50.08 хувь нь эрчим хүч, 48.51 хувь нь хөдөө аж ахуй, 0.95 хувь нь аж үйлдвэр, үлдсэн 0.46 хувь нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Хүлэмжийн хийн бүтцээр нь авч үзвэл 46.41%-ийг нүүрсхүчлийн давхар исэл буюу нүүрсхүчлийн хий (CO<sub>2</sub>), 32.89 хувийг метан хий (CH<sub>4</sub>), 20.4 хувийг азотлог исэл (N<sub>2</sub>O), 0.28 хувийг гидрофторт нүүрстөрөгч (HFCs) тус тус эзэлж байна.

Хүлэмжийн хийн ялгарлыг үндэсний хөгжлийн явцтай уялдуулан 2010–2030 оны байдлаар тооцож үзэхэд 2010 онд хүлэмжийн хийн ялгарал 25.8 сая т CO<sub>2</sub> –экв. байсан бол 2030 онд 74.2 сая т CO<sub>2</sub> –экв. болж 2.76 дахин өсөх төлөвтэй байна. Энэхүү өсөлтөд эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарын ялгарал зонхилох хэвээр байх боловч, аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин 4.1 хувиас 16.6 хувь болж өсөх, харин хог хаягдлын салбарын хувийн жин төдийлөн их өөрчлөгдөхгүй буюу 1 хувиас бага байна.

Уур амьсгалын сангийн хөрөнгө оруулалтыг Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах төсөл, бизнесүүдийг дэмжих чадавхыг бэхжүүлэхэд Монголын ногоон санхүүжилтийн корпорацийг 2017 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Дэлхийн ногоон өсөлтийн институт хамтран байгуулсан. Учир нь манай улс уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг бүсэд оршдог ба хөрсний доройтол, биологийн олон янз байдал алдагдсан зэрэг эрсдэл учирсан. Ялангуяа өвлийн улиралд зуд тохиолдох магадлал нэмэгдэж, Улаанбаатар хотын хувьд агаарын бохирдлоор дэлхийд дээгүүрт орох болсон зэрэг шалтгаанууд хамаарна.

Уур амьсгалын сангийн хөрөнгө оруулалтыг байгууллагын байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг үнэлэх чадавхыг хангасан санхүүгийн байгууллагаар уг зээлийг дамжуулан олгох юм. Үүнд, НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сан (УАНС)-ийн Удирдах зөвлөлийн 27 дахь удаагийн хурал 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулагдаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан ногоон санхүүгийн байгууллага болох Монголын ногоон санхүүгийн корпораци (МНСК)-ийг үүсгэн байгуулах 50 сая ам.долларын төслийн саналыг дэмжин, нийт 27 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг УАНС-ийн итгэмжлэгдсэн байгууллага болох ХасБанкаар дамжуулан олгох шийдвэр гарсан /ТоС холбооны жилийн тайлан 2020/.

Нөгөө талаас Уур амьсгалын сангаас санхүүжилт авах хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь хүрэн эдийн засаг бус, бодитоор хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах төсөл байх шалгууртай.





## ХЭРХЭН УХААЛАГ ЗЭЭЛ АВАХ ВЭ?

Зээл гэдэг нь банк, санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтыг

- тодорхой хугацаанд
- хүүний хамт
- эргүүлэн төлөх нөхцөлтэй авахыг хэлдэг.

Та 2 болон түүнээс дээш асуултад “**ҮГҮЙ**” гэж хариулсан бол худалдан авалт хийхээ түр “**ХОЙШЛУУЛААРАЙ**”

- 1 Та **тогтвортой** ажил эрхэлдэг үү?
- 2 Танд цалингаас гадна **нэмэлт** орлогын эх үүсвэр байгаа юу?
- 3 Та сар бүр **тогтмол хуримтлал** үүсгэж чаддаг уу?
- 4 Танд худалдан авалт хийх **урьдчилгаа төлбөр** байгаа юу?
- 5 Таны **зээлийн түүх** сайн уу?
- 6 Таны “өр, орлогын эх үүсвэрийн харьцаа” **50 хувиас** бага уу?
- 7 Та өөрийн шийдвэртээ бүрэн дүүрэн **хариуцлага** хүлээхдээ итгэлтэй байна уу?

Ирээдүйн орлоготойгоо уялдуулах



Одоогийн санхүүгийн байдлаа тодорхойлох



Тансаг хэрэглээнд бус, өөрийн зорилгоо биелүүлэхэд зээл авах



Зээлээр худалдан авалт хийхээс өмнө өөрөөсөө бататгах асуулт асууж хэвших



Өөрт хамгийн тохиромжтой эх үүсвэр сонгох



Зээл авахаар шийдсэн бол дахин нэг бодоод Үзээрэй



Зээлийн гэрээгээ битгий унш

Орлого байхгүй ч хүмүүсээс мөнгө зээлээд бай

Орлого, зарлагын жагсаалт гаргалгүйгээр хүссэнээрээ мөнгөө үр



Зээлээ хугацаанд нь төлөөд хэрэггүй

Нэмэлт орлогын эх үүсвэр хэрэггүй

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД

*Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.*

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь хэмжээ 8.2 байна. Олон улсын эдийн засгийн судалгааны байгууллагаас эрхлэн гаргадаг хөрөнгийн зах зээлийн үнэлгээг ДНБ-д эзлэх хувиар тооцон гаргасан судалгаанаас үзэхэд эдийн засгийн хувьд хурдацтай хөгжиж байгаа орнуудын хөрөнгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувь нийт дунджаас өндөр байна. Жишээ нь: The Global Ecomomy сайтаас эрхлэн гаргадаг 2019 оны судалгаагаар Хонконг Улсын хувьд хөрөнгийн зах зээл үнэлгээ нь ДНБ-ээс 13 дахин том буюу харьцаа нь 1,339%, Швейцар Улсын хувьд 260.92%, Сингапур Улсын хувьд 187.41%, Япон Улсын хувьд 121.83%-тай байна. Эдийн засгийн онолоор хөрөнгийн зах зээлийн хэмжээг нэмэгдүүлэх болон хөрөнгө оруулалтын бүтээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг өдөөж болно гэж үздэг. Хөрөнгийн зах зээл хөгжсөнөөр бий болох давуу талууд нь эдийн засгийн хөгжил (ажлын байр нэмэгдэж, зээлийн хүү буурах)-ийг бий болгох хөшүүрэг болж, бизнесүүдийг дэмжих үндсэн механизмын нэг болж өгдөг.

Монголын үнэт цаасны зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулсан дүнг FTSE жагсаалтад багтах фронттиер зах зээлийн улс орнуудтай харьцуулахад 3 дугаарт жагсаж байна. Энэ нь бусад ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур үзүүлэлт юм.

2011–2020 оны ҮЦК-уудын цэвэр ашиг болон бусад санхүүгийн салбарын оролцогчид болох даатгал, ББСБ, ХЗХ-той ашигт ажиллагаагаар нь харьцуулж үзэхэд ҮЦК-уудын ашигт ажиллагаа дундаж түвшнээс бага байна.

Дээрх баримтуудаас харахад ҮЦК-ууд ашигт ажиллагаа болон бүтээмжийн хувьд бусад салбарын дундаж түвшинтэй харьцуулахад бага байна. Судлаачийн зүгээс ҮЦК-ийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, ашигт ажиллагаа болон

#### Гүйцэтгэсэн:

Санхүү эдийн засгийн их сургуулийн магистрант Ц.Чанцал

бүтээмжийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэн дараах 2 асуудлыг дэвшүүлсэн. Үүнд:

Үнэт цаасны компаниудын үйл ажиллагаа, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн тулгамдаж буй асуудал

**Шинжилгээ 1:** Шинжилгээний уг хэсэгт тайлбарлагдаг коэффициентоор ҮЦК-уудын цэвэр ашгийн түвшинг авч түүнд тайлбарлагч хувьсагч бүр хэрхэн нөлөөлж байгаа талаар судлаачийн дэвшүүлсэн таамгийг авч үзнэ. Уг хамаарлыг харснаар ҮЦК-уудын үр ашгийг нэмэгдүүлж болох гол хүчин зүйлсийг илрүүлэх зорилготой болно.

Цахим арилжааны системтэй эсэх

DE харьцаа

Харилцагчдын тоо

Шимтгэлийн хэмжээ гэсэн 4 хүчин зүйлийг цэвэр ашгийн түвшинтэй хамааруулан шинжилж үзлээ.

$$\text{Net profit} = 1.02 * \text{ONLINE} - 0.55 * \text{D/E} + 7.6 * \text{CUSTOMER} - 1 * \text{FEE} - 0.44$$

Хамаарлын шинжилгээний тэгшитгэлийн харилцагчийн тоо болон шимтгэлийн хэмжээ гэсэн 2 хувьсагч мөн үлдэгдлийн R value 0.05-с их буюу ач холбогдолгүй цэвэр ашгийн түвшинд нөлөөгүй харагдаж байна. Энэ нь харилцагчийн тоо болон шимтгэлийн хэмжээ хоорондоо хүчтэй хамааралтай байгаагаас шалтгаалсан гэж үзэж байна. Иймд харилцагчийн тоо, шимтгэлийн хэмжээ аль нэгнийх нь эсвэл хоёулангийнх нь тоон мэдээллийг регрессийн загвараас хасаж үнэлж үзэв.

Цэвэр ашгийн түвшин нь дараах хүчин зүйлсээс хамааралтай эсэх:

Цахим арилжааны системтэй эсэх

DE харьцаа

$$\text{Net profit} = 0.89 * \text{ONLINE} - 0.55 * \text{D/E} - 0.33$$

Ач холбогдолгүй гарман 2 хувьсагчийн аль алиныг хасаж үзэхэд хувьсагчууд төдийгүй тэгшитгэл маань бүгд ач холбогдолтой гарч байна. Шинжилгээний үр дүнгээс үзэхэд цахим арилжааны систем ашиглалт болон өр эздийн өмчийн харьцаа гэсэн үзүүлэлтүүд цэвэр ашгийн түвшинд нөлөөтэй гэж харагдаж байсан. Өөрөөр хэлбэл цахим арилжааны системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь ҮЦК-уудын цэвэр ашгийн түвшинд эергээр нөлөөлж байсан. Харин D/E буюу өр эздийн өмчийн харьцаа болон цэвэр ашгийн түвшин хоорондоо сөрөг хамааралтай байсан. Энэ нь компани аль болох өрийн санхүүжилт бага авах, өрийн хэмжээг бууруулснаар цэвэр ашгийн түвшинг сайжруулах боломжтой гэсэн дүгнэлт гарч байна.

**Шинжилгээ 2:** Санхүүгийн салбарын хөгжлийг тодорхойлогч дэлхийн банкны тодорхойлсон дөрвөн хүчин зүйлээс зах зээлийн хэмжээ, нэвтрэлт, тогтвортой байдлын үзүүлэлтүүдээр Сингапур, Тайланд, Малайз, Индонез, Филиппин гэсэн улсуудыг сонгон МУ-тай харьцуулан хувьцааны зах зээлийн хөгжлийн түвшинг үнэлсэн.

Хүснэгт 1. Тооцооллын үр дүн


Үзүүлэлт	Сингапур	Индонез	Тайланд	Монгол	Филиппин	Малайз
<b>Хэмжээ</b>						
ЗЗҮ	10.0	7.5	8.2	-	3.9	5.8
ЗЗҮ/ДНБ	10.0	2.5	5.6	-	3.9	5.9
Нийт арилжааны дүн	3.1	3.2	10.0	-	0.8	3.0
<b>Дундаж</b>	<b>7.7</b>	<b>4.4</b>	<b>7.9</b>	<b>-</b>	<b>2.9</b>	<b>4.9</b>
<b>Нэвтрэлт</b>						
Бүртгэлтэй компанийн тоо	3.1	6.2	7.0	0.6	-	10.0
Бүртгэлтэй компанийн өсөлт	-	10.0	5.4	2.3	2.1	4.8
Хиршманы индекс NNI	9.9	10.0	10.0	-	9.4	9.7
<b>Дундаж</b>	<b>4.3</b>	<b>8.7</b>	<b>7.5</b>	<b>1.0</b>	<b>3.8</b>	<b>8.2</b>
<b>Тогтвортой байдал</b>						
PE харьцаа	2.1	2.4	1.9	-	5.0	10.0
PB харьцаа	-	10.0	4.1	4.7	4.7	4.1
Ногдол ашгийн өгөөж	10.0	3.8	5.4	3.8	-	4.2
<b>Дундаж</b>	<b>4.0</b>	<b>5.4</b>	<b>3.8</b>	<b>2.8</b>	<b>3.2</b>	<b>6.1</b>
<b>Нийт оноо</b>	<b>16.1</b>	<b>18.5</b>	<b>19.2</b>	<b>3.8</b>	<b>10.0</b>	<b>19.1</b>



*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Тооцооллын үр дүнгээс харахад зах зээлийн хэмжээгээр Тайланд Улс, нэвтрэлтийн түвшингээр Индонез Улс, тогтвортой байдлын үзүүлэлтээр Тайланд, Малайз Улс харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Монгол Улсын хувьд зах зээлийн хэмжээ, нэвтрэлт, тогтвортой байдлын үзүүлэлтээр бусад улсуудтай харьцуулахад маш муу оноо авсан бол манай улстай ДНБ ойролцоо улсууд харьцангуй сайн үзүүлэлттэй байна.


Зураг. Сингапур, Индонез улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлт



*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Сингапур, Индонез Улсын хөгжлийн түвшинг үзүүлэлт бүрийн хувьд харьцуулан харвал Сингапур зах зээлийн хэмжээгээрээ 7.7 оноотой илүү давуу байгаа бол тогтвортой байдал болон нэвтрэлтийн түвшингээр Индонез Улс илүү үзүүлэлттэй байна.

Зураг. Малайз, Тайланд улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлт




*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Нийт оноогоор хамгийн өндөр байгаа Тайланд болон Малайз Улс нь нэг хүнд ногдох ДНБ түвшингээрээ ойролцоо түвшинтэй байсан бөгөөд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшингээрээ мөн адил ойролцоо оноо буюу

Тайланд 19.2, Малайз 19.1 байна. Энэ нь эдийн засгийн хөгжлийн түвшин нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэйг батлан харуулж байна.

Зураг. Монгол, Филиппин Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлт




*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Монгол болон Филиппиний нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ ойролцоо түвшинд байсан боловч Монголын хөрөнгийн зах зээл Филиппиний зах зээлтэй харьцуулахад харьцангуй жижиг буюу нийт 6.2 оноогоор бага байна. Харин Филиппин Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд нэрлэсэн ДНБ-ий хувьд ойролцоо бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад муу үзүүлэлттэй байна.

**Судалгааны үр дүн:**

Зураг. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтийн үр дүн



*Эх сурвалж: Судлаачийн тооцоолол*

Үр дүнгээс харахад зах зээлийн хэмжээгээр Тайланд Улс, нэвтрэлтийн түвшингээр Индонез Улс, тогтвортой байдлын үзүүлэлтээр Тайланд, Малайз Улс харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Харин нийт үнэлгээний хувьд Монгол Улс нийт авах 30 онооноос 3.8 оноо буюу хамгийн бага оноо авсан шалтгаан нь хэмжээ болон зах зээлийн нэвтрэлт гэсэн хөгжлийн үзүүлэлтүүд дээр оноо аваагүйтэй холбоотой байна.

Манай улсын хувьд хөрөнгийн зах зээлийн хэмжээг хөгжүүлэх тал дээр ҮЦК-ууд дотооддоо цахим арилжааны системийг ашиглах, санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг

сайжруулах мөн олон улсын туршлагын дагуу институцийн хөрөнгө оруулагчдыг дотооддоо бий болгох, гадны институцийн хөрөнгө оруулагчдыг өөрийн хөрөнгийн зах зээл дээр татан оролцуулах, дотоодын томоохон компаниудыг нээлттэй компани болгох замаар зах зээлийн нээлттэй байдал, нэвтрэлтийн түвшинг нэмэгдүүлэх цаашлаад хөрөнгө оруулалтын өргөн боломжийг бүрдүүлснээр төвлөрлийг бууруулах зэрэг боломжтой юм.

### Эх сурвалж:

- ◇ Б.Батчулуун (2018) “Хөрөнгийн зах зээл дэх брокер, дилерийн компанийн оролцоо, түүнийг нэмэгдүүлэх арга зам”
- ◇ Л.Энхсүвд (2017) “Үнэт цаасны компанийн брокерийн үйлчилгээг сайжруулах нь”
- ◇ Т.Отгонжаргал (2016) “Компаний шийдвэр гаргалтад тайлангийн шинжилгээг ашиглах нь /ҮЦК компанийн жишээн дээр/ Магистрын зэрэг горилсон судалгааны ажил
- ◇ Санхүүгийн зохицуулах хороо (2017) “Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг”,
- ◇ МҮЦАЭХ (2019) “Үнэт цаасны компаниудын арилжааны шимтгэлийн судалгаа” 2019
- ◇ Д.Баярсайхан “Зээлийн хүүг бууруулах стратеги” ярилцлага, Санхүүгийн зохицуулах хороо
- ◇ Ядамсүрэн.Ж (2001) Үнэт цаасны зах зээл. Улаанбаатар хот: Ти энд Ю принтинг
- ◇ TheGlobalEconomy.com “ Stock market Cap by countries 2019 ”
- ◇ WorldBank.org “Capital Markets Development Causes, Effect and Sequencing” (Kaserer and Rapp, 2014)
- ◇ World Bank Group (2019) “Capital Market Development Causes, Effects and Sequencing”
- ◇ OECD Development Co-Operation Report (2014) “Mobilising resources for Sustainable Development”
- ◇ Ahmad Dahiyat, (2018) “Determinants of Profitability: Evidence from Brokerage Companies Listed at Amman Stock Exchange”, Journal of Economics and Public Finance
- ◇ Y.Bayar, A.Kaya, M.Yildirim, (2013) “Effects of Stock Market Development on Economic Growth: Evidence from Turkey” International Journal of Financial Research
- ◇ Charles Amo Yartey, Charles Komla Adjasi (2007) “Stock Market Development in Sub-Saharan Africa: Critical Issues and Challenges” International Monetary Fund
- ◇ Pariyada Sukcharoensin, Sorasart Sukcharoensin (2013), “The Analysis of Stock Market Development Indicators: Evidence from the ASEAN-5 Equity Markets”, Зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийн судалгаа ASEAN –5 орнуудын жишээн дээр
- ◇ Md. Zakir Hosain (2015) “The Determinants of Stock Market Development: A Study on Dhaka Stock Exchange Limited”, Хөрөнгийн зөх зээлийн хөгжлийг тодорхойлогч үзүүлэлтүүд Даха-н хөрөнгийн биржийн жишээн дээр

## ХЭРЭГЛЭГЧ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан санал, дүгнэлт гаргаж хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2021 оны 2 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр цаасаар 180, цахимаар 94, нийт 274 өргөдөл ирсэн. Үүнээс 162 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 18 өргөдөл гомдол хянах шатанд явж байна.

Хүснэгт. Нийт өргөдлийн тоо (улирлаар)

№	Салбар	2020/II	2021/II
1	Даатгал	61	33
2	Үнэт цаас	33	28
3	Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/	36	18
4	Хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/	3	3
	<b>Нийт</b>	<b>133</b>	<b>82</b>

Өргөдөл, гомдлын утга болон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар нийт 499 өргөдөл, гомдол, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 98 өргөдөл, 2021 оны 2 дугаар улиралд цахимаар 94 өргөдөл ирснээс үнэт цаастай холбоотой 40, даатгал 2, ББСБ 20, ХЗХ 4, зохицуулалтад хамааралгүй 17 гомдол ирснийг тухай бүр хариуг өгч ажилласан. Мөн цаасаар нийт 82 өргөдөл, гомдол тус тус ирсэн байна.

Салбарын үзүүлэлтүүд: Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Санхүүгийн зохицуулах хороонд хандаж, 2020 он, 2021 оны 2 дугаар улиралд цаасан хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

Санхүүгийн зохицуулах хороонд 2021 оны 2 дугаар улиралд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд өргөдөл гомдлын тоо өмнөх оны мөн үеийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад даатгал 45.9 хувь, үнэт цаасны зах зээл 15.2 хувь, банк бус санхүүгийн байгууллага 50.0 хувь, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл буураагүй байна.

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2020 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 130 өргөдөл, гомдол ирснээс 123 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 7 өргөдөл хянагдах шатанд, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 21 өргөдөл, гомдол ирснээс 9 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 12 өргөдөл хянагдах шатанд байна.

Дээрх өргөдлүүдийн 14.2 хувийг эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байгаа бөгөөд эдгээрийг өмнө нь Үнэт цаасны хороо /хуучнаар/ –ноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон брокер, дилерийн компаниудаар дамжуулан арилжаалсан байна. Хувьцааны бүртгэл, дансны мэдээлэл шалгуулахаар 21.4 хувь, Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг 17.9 хувь, Хөрөнгө оруулалтын сан 10.7 хувийг тус тус эзэлж байна.

### ДААТГАЛЫН САЛБАР

2020 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор өссөн дүнгээр нийт 269 өргөдөл ирснээс хугацаандаа шийдвэрлэгдсэн 262, хуулийн хугацаанд хянагдаж байгаа 7 өргөдөл, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэн, хуулийн

этгээдээс даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 59 өргөдөл, гомдол ирснээс 51 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 8 өргөдөл, гомдол хянагдаж, 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 33 өргөдөл ирснээс 27 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 6 өргөдөл хянагдах шатанд байна.

Санхүүгийн зохицуулах хороонд 2020 онд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, 93 даатгуулагчийн нөхөн төлбөрт нийт 1,557.6 сая төгрөгийг олгуулахаар шийдвэрлэж, үүнээс нэр бүхий 46 иргэн, хуулийн этгээдэд нийт 444.6 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон, 2021 онд өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан даатгалтай холбоотой 21 иргэн, хуулийн этгээдэд 118,578,157 төгрөгийн нөхөн төлбөрийг олгохоор урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 6 иргэн, хуулийн этгээдэд 8,110,200 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

### **БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**


2020 оны жилийн эцсийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл

ажиллагаатай холбоотой нийт 90 өргөдөл, гомдол, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 15 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. 2021 оны 2 дугаар улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 18 өргөдөл, гомдол ирснээс 13 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 5 өргөдөл хянагдах шатанд байна.

Өмнөх улиралтай харьцуулбал, нийт өргөдлийн тоо 28.6 хувиар өссөн бол эдгээрийн 94.4 хувийг банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, зээлийн гэрээний маргаан, зээлийн мэдээллийн санд бүртгэсэн зээлийн ангилалтай холбоотой өсөлт бүхий маргаан эзэлжээ.

### **ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

2020 оны байдлаар ХЗХ-ны үйл ажиллагаатай холбогдуулан нийт 10 өргөдөл, гомдол, 2021 оны 1 дүгээр улиралд 3 өргөдөл, гомдол, 2021 оны 2 дугаар улиралд 3 өргөдөл, гомдол тус тус ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ТУЗ-ИЙН ШИНЭЧЛЭЛТ

“Прайс вотэр хаус кооперс”-ээс жил бүр захирлуудын дунд судалгаа явуулдаг бөгөөд тус судалгаагаар дамжуулан захирлуудын гүйцэтгэлийг үнэлүүлэх, ТУЗ-ийн гишүүдийг солих шаардлагатай эсэх талаар санал асуулга явуулдаг. Судалгаанд оролцогчдын зүгээс нэг эсвэл хэд хэдэн ТУЗ-ийн гишүүнийг солих санал өгөх нь жилээс жилд ихсэх хандлагатай байсан бөгөөд 2020 онд нийт судалгаанд оролцогчдын 49 хувь нь ТУЗ-ийн гишүүдийг солих саналтай байсан байна. ТУЗ-ийн үйл ажиллагаанд коллегиализм хэр чухал болохыг харгалзан үзэхэд тус судалгааны үр дүн нь маш муу санагдаж магадгүй.

Гэвч энэ нь дээд шатны удирдлагуудын судалгаатай харьцуулахад тийм ч муу үзүүлэлт биш юм. Дээд шатны удирдлагуудын дунд дээрхтэй ижил судалгаа явуулахад тэдний 4/5-өөс илүү нь буюу 82 хувь нь ТУЗ-ийн аль нэг гишүүнийг солих саналтай байсан бол 43 хувь нь хоёр эсвэл түүнээс дээш захирлыг солих шаардлагатай гэж санал оруулсан байдаг.

Энэхүү дээд шатны удирдлагуудын зүгээс ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар явуулсан судалгааны хариу нь захирлуудад маш таагүй сэтгэгдэл төрүүлэх нь гарцаагүй юм. Гүйцэтгэх удирдлагын зүгээс ТУЗ-ийн үйл ажиллагаанд шударгаар үнэлэлт өгөх нь ховор байдаг ч тус судалгааны үр дүн нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт хийх шаардлага байгааг, ямар нэгэн шинэчлэлт дутагдаж байгааг илтгэж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдээс дурдвал:

ТУЗ-ийн залгамж халааны бодлого:

Гүйцэтгэх удирдлагуудын зүгээс ТУЗ-ийн гишүүдэд шинэчлэлт хийх шаардлагатай гэж үзсээр байгаа ч жил бүр захирлуудын дунд явуулдаг судалгаагаар “ТУЗ-ийн гишүүдийн цөөнх нь залгамж халааны бодлогод ач холбогдол өгч ажилладаг” гэдгийг олж тогтоосон. Гүйцэтгэх удирдлагуудын 10 хувь нь тэдгээрийн ТУЗ-д залгамж халааны төлөвлөгөө огт байдаггүй харин 33 хувь нь аргацаасан гэж хариулжээ. Залгамж халааны бодлоготой компаниудын хувьд ТУЗ-ийн гишүүдийн дөнгөж 49 хувь танилцсан байдаг нь мөн судалгаагаар тогтоогджээ.

Компанийн үйл ажиллагааг тасралтгүйгээр хэвийн явуулах залгамж халааны бодлогыг тодорхойлоход ТУЗ-ийн гишүүдийн одоогийн ур чадвар, ирээдүйд эзэмших шаардлага бүхий ур чадварыг харгалзан үздэг. Залгамж халааны бодлого сайтай ТУЗ нь мэргэжлийн болон хувийн ямар шинж чанарууд дутагдаж байгаагаа оновчтой тодорхойлсноор ямар ч үед сул орон тоо гарсан тохиолдолд тохирсон нэр дэвшигчийг сонгох боломжоор хангагддаг.

Захирлуудын нөөц бололцоог үнэлэх:

Дээд шатны удирдлагуудын судалгаанаас үзэхэд хамгийн тодорхой харагдах нэг зүйл нь гүйцэтгэх удирдлагын зүгээс ТУЗ-ийн гишүүдийн ажилдаа хэрхэн хариуцлагатай хандаж байгаад үргэлж эргэлздэг байна. ТУЗ-ийн нийт гишүүдийн 53 хувь нь хяналтын үүргээ хэрэгжүүлэхдээ хангалттай цаг зарцуулдаг харин ердөө 37 хувь нь бүрэн дүүрэн өөрийгөө дайчилж ажилладаг гэж хариулсан байдаг.

Судалгаагаар захирлууд болон ТУЗ-ийн гишүүдийн байр суурийн зөрүүтэй байдлыг онцлон тэмдэглэсэн байна. Захирлуудын 38 хувь нь ТУЗ-ийн гишүүн хэтэрхий олон гэж үзсэн бол ТУЗ-ийн гишүүдийн ердөө 6 хувь нь ингэж үзсэн байна. ТУЗ-ийн зүгээс дотоод нөөц бололцоогоо тодорхойлж залгамж халааны бодлогод ач холбогдол өгч ажиллах зайлшгүй шаардлагатай.

Холч хараа:

Төгсгөлд нь хэлэхэд судалгааны үр дүн бүгд муу үнэлгээтэй байгаагүй гэдгийг онцлох хэрэгтэй. Удирдах ажилтнуудын бараг 94 хувь нь ТУЗ-ийн компанийн стратегийн бодлогыг тодорхойлох тал дээр өндөр үнэлгээ өгсөн байна. Мөн захирлуудын дийлэнх олонх буюу 89 хувь нь ТУЗ-ийн зүгээс компанийн үндсэн эрсдэлийг тодорхойлох, 87 хувь нь хувьцаа эзэмшигчдийн тогтвортой байдлыг хангах, 86 хувь нь өрсөлдөх чадвар чадамжийг тус тус өндрөөр үнэлсэн. Гүйцэтгэх удирдлагууд ТУЗ-д ийнхүү шүүмжлэлтэй байдаг нь таагүй байж болох юм. Гэсэн хэдий ч судалгаанаас харахад гүйцэтгэх удирдлагын түвшинд ч, ТУЗ-д ч шинэчлэлт өөрчлөлтийг дэмжигчид хэзээд байх нь харагдаж байна. Иймд энэхүү судалгааг эерэгээр хүлээн авч ашиглах хэрэгтэй.

*Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance*

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### КОВИД–19–ИЙН ҮЕЭР УЛСУУДЫН ҮНЭТ ЦААСНЫ САЛБАРТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Коронавируст халдварт өвчин (Ковид–19) цар тахал нь дэлхийн ихэнх улс орнуудын нийгэм, эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлж байна. 2020 оны Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр эхний 5–т эрэмбэлэгдсэн улсууд болох АНУ, БНХАУ, Япон, ХБНГУ, Энэтхэг, Их Британи улсуудын үнэт цаасны салбарт коронавируст халдвар (Ковид–19) нь хэрхэн нөлөөлсөн, ямар өөрчлөлтийг бий болгосон талаар дэлгэрэнгүй хүргэж байна.

#### Америкийн Нэгдсэн Улс

*АНУ–д коронавируст халдварын хамгийн анхны тохиолдол 2020 оны 1 дүгээр сарын 20–ны өдөр илэрсэн бөгөөд 2019–2020 оны байдлаар ДНБ 2.9 хувиар буурсан бол ажилгүйдлийн түвшин 4.6 хувиар нэмэгдсэн байна.*

Коронавируст халдварт өвчин (Ковид–19) нь АНУ–ын эдийн засагт урьд өмнө тохиож байгаагүй хямралд хүргэж, АНУ–ын хөрөнгийн зах зээлд уналтыг авчирсан. China Daily эх сурвалжийн мэдээлснээр АНУ–ын зах зээл 1987 оноос хойших түүхэн дэх хамгийн муу үе дээрээ ирээд байна. Үүний үр дагаварт хувьцааны үнэ огцом унаж, үнийн хэлбэлзэл эрс нэмэгдсэний улмаас хөрөнгө оруулагчид ихээхэн хэмжээний алдагдал хүлээсэн. Хөрөнгийн зах зээлийг тогтворжуулах талаар судалгаа, шинжилгээ одоог хүртэл хийгдсээр байгаа ба амжилттай үр дүн үзүүлээгүй байна.

Судалгааны ажлын үр дүнгээс харахад цар тахлын хямрал нь зах зээлийн үр ашиггүй байдалтай шууд холбоотой байсан ба жижиглэн худалдаа эрхлэгчид болон дамын наймаа эрхлэгчдэд ашигтай боломжуудыг бий болгосон байв. Цаашилбал, Ковид–19 нь санхүүгийн хомсдолтой зах зээлд иргэд хоорондын орлого, баялгийн тэгш бус байдлыг өдөөсөн байна. (Hui Hong, Zhicun Bian & Chien–Chiang Lee, 2021)

#### Бүгд Найрамдах Хятад Ард Улс

*БНХАУ–д коронавируст халдварын хамгийн анхны тохиолдол 2019 оны 12 дугаар сарын 1–ны өдөр илэрсэн бөгөөд 2019–2020 оны байдлаар ДНБ 3.6 хувиар, ажилгүйдлийн түвшин 0.4 хувиар тус тус*

*нэмэгдсэн байна.*

Цар тахлын улмаас БНХАУ–ын аялал жуулчлалын салбарт хамгийн ихээр нөлөөлсөн. Сүүлийн 20 гаруй жил дэлхийн эдийн засагт аялал жуулчлалын салбарын оруулсан хувь нэмэр тасралтгүй нэмэгдэж, олон орны хувьд энэ нь эдийн засгийнхаа хамгийн идэвхтэй, хамгийн хурдацтай хөгжиж буй салбар болсон. Ялангуяа БНХАУ–ын аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж, жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж, үнэт цаасны салбарын өсөлтөд эерэгээр нөлөөлж байсан ч, коронавируст халдвар (Ковид–19) тархсанаар Хятадын аялал жуулчлалын салбар уналтад орсон. Үүнд:

Ковид–19 цар тахал нь Хятадад бүртгэлтэй аялал жуулчлалын компаниудын хувьцааны өгөөжид сөргөөр нөлөөлсөн. Цаашид үргэлжлэн тархсаар байвал, үнэт цаасны салбарт үзүүлэх муу нөлөөлөл өргөжсөөр байх болно гэж судлаачид үзсэн.

Яг одоогийн байдлаар Засгийн газраас хариу арга хэмжээ хэрэгжүүлж байгаа ч жуулчлалын салбарын хувьцааны өгөөж сөрөг хэвээр байгаа нь урвуу хамааралтай байгааг илтгэж байна. Цаашид хувьцааны өгөөжийг эерэг болгож, хөрөнгийн зах зээлийг тогтворжуулахын тулд Засгийн газрын зүгээс сайжруулсан арга хэмжээ авч ажиллаж байна.

#### Япон Улс

*Япон улсад коронавируст халдварын хамгийн анхны тохиолдол 2020 оны 1 дүгээр сарын 16–ны өдөр илэрсэн бөгөөд 2019–2020 оны байдлаар ДНБ 3.4 хувиар буурсан бол ажилгүйдлийн түвшин 0.6 хувиар нэмэгдсэн байна.*

Токиогийн хөрөнгийн биржийн 33 салбарын индексүүдийн зөвхөн 1 үзүүлэлт өсч, бусад индексүүд нь буурсан үзүүлэлттэй байв. Эдийн засаг тодорхой хэмжээгээр сайжирч байгаа ч индексийн үзүүлэлт буурсан хэвээр байх нь хямралын нөлөөлөлтэй ижил байна.

Япон улсын Ковид–19 халдварын нийт тохиолдлын тоо АНУ, Энэтхэг, Их Британи зэрэг улстай харьцуулахад харьцангуй


бага байгаа ч, хөрөнгийн зах зээл нь 30 орчим хувиар буурсан нь АНУ-тай ижил түвшинд байна. Шинжээчдийн дүгнэлтээр, Ковид-19-ийн улмаас АНУ-ын орон сууц, цахилгаан холбооны салбарын ханш суларсны улмаас Японы тус салбарын хувьцааны үнэд сөргөөр нөлөөлсөн байна.

Япон улс нь машин тоног төхөөрөмжийн экспортын хэмжээгээр дэлхийд 2 дугаарт жагсдаг томоохон экспортлогч улс билээ. Эдийн засгийн байдалтай нягт холбоотой байдаг машин механизм, газар тариалангийн тоног төхөөрөмж борлуулдаг компаниудын хувьцааны үнэд мэдэгдэхүйц хэмжээний өөрчлөлт гарсан байна. /Daikin Industries 3.7 хувиар, Komatsu 3.9 хувиар, Kubota 2.7 хувиар тус тус буурсан/. Ковид-19-ийн улмаас дэлхий даяар автомашины чипний хомсдол бий болсноор, Япон улсын машины экспорт буурсан. Үр дүнд нь хувьцааны үнэ буурч, хөрөнгийн зах зээлд өөрчлөлт үзүүлсэн.

### Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

*ХБНГУ-д коронавируст халдварын хамгийн анхны тохиолдол 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр илэрсэн бөгөөд 2019-2020 оны байдлаар ДНБ 2.1 хувиар буурсан бол ажилгүйдлийн түвшин 1.2 хувиар нэмэгдсэн байна.*

Коронавируст халдвар дэгдэлтийн үеэр Герман улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хамгийн том, хөрвөх чадвар сайтай 30 компанийн үзүүлэлтийг харуулдаг DAX нь огцом савлагаатай байсан.



Европ дахь аялал жуулчлалын салбарын хувьцаа ихээр унасан. /Air France-KLM AF 2.13 хувиар, Lufthansa LHA 2.37 хувиар, EasyJet EZJ 3.95 хувиар, Ryanair RYA 2.53 хувиар, IAG IAG 2.00 хувиар, InterContinental Hotels Group IHG 2.3 хувиар тус тус буурсан/ Тэр дундаа Герман улсын аялал жуулчлалын

хувьцааны үнэ илүүтэй буурсан байна. Герман улс нь машин тоног төхөөрөмжийн экспортоор дэлхийд тэргүүлэгч улс бөгөөд цар тахлын үед экспортын хэмжээ буурахад эдийн засаг цочролд орж, хувьцааны үнэ ихээр буурсан.

Цар тахлын эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй авснаар бусад орнууд шиг их хэмжээний алдагдал хүлээж, эдийн засгийн хямралд өртөөгүй. Герман улсын ДНБ нь 2019-2020 онд 4.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2021 оны 2 дугаар улирлын байдлаар одоог хүртэл хөл хорио тогтоосон байгаа ч 2022 он хүртэл хөрөнгийн зах зээл нь урьдын адил тогтворжихгүй байх магадлалтай гэж судлаачид үзсэн.

### Их Британи Улс

*Их Британи улсад коронавируст халдварын хамгийн анхны тохиолдол 2020 оны 1 дүгээр сарын 31-ны өдөр илэрсэн бөгөөд 2019-2020 оны байдлаар ДНБ 6.7 хувиар буурсан бол ажилгүйдлийн түвшин 0.6 хувиар нэмэгдсэн байна.*

Их Британи улсын төв банк нь зээлийн хүүг бууруулснаар, зээлийг хямд болгож, эдийн засгаа сайжруулах боломжтой гэж үзэн арга хэмжээ авсан байна. Ингэснээр 2021 оны 1 дүгээр сард эдийн засаг сайжирч эхэлсэн ч, энэ нь Нэгдүгээр сарын нөлөөлөл (January effect) хэмээн нэрлэгддэг жил бүр илэрдэг үзэгдэл байна гэж зарим судлаачид үзсэн.


Цар тахлын дараагаар эдийн засаг сайжирсан ч “сорви” тогтон, хэвийн байдалдаа ороход хүндрэлтэй гэж дүгнэсэн байна. Үүний эсрэг Засгийн газрын зүгээс бизнес эрхлэгчид, ажилчдыг дэмжих бодлого хэрэгжүүлэн, арга хэмжээ авч ажиллаж байгаа. Энэ нь ажилгүйдлийн түвшинг бууруулж, эдийн засгийн тодорхойгүй байдлыг арилгах оролдлого юм. 2021 оны 3 дугаар сард Засгийн газраас дэмжлэгийн хөтөлбөрүүд, нэмэлт арга хэмжээг авч, эдийн засгаа дээшлүүлэх үйл ажиллагаа цаашид хийнэ гэдгээ илэрхийлсэн байв.

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

S&P 500 /<sup>^</sup>GSPC/


**4,358.69** +35.63 (+0.82%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Nikkei 225 /<sup>^</sup>N225/


**27,548.00** +159.84 (+0.58%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

FTSE 100 /<sup>^</sup>FTSE/


**7,005.32** +7.04 (0.10%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

NASDAQ Composite (^IXIC)

**14,631.95** +133.08 (+0.92%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia